



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/156

Улаанбаатар хот

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын
даалгавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" 2019 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн өмнөх боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдалд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлын даалгаврыг нэгдүгээр, Ерөнхий боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдалд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлын даалгаврыг хоёрдугаар, Мэргэжлийн болон техникийн боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдалд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлын даалгаврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын даалгаврын хүрээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нарийвчилсан удирдамжийг Хүний эрхийн үндэсний комисстой хамтран баталж хэрэгжүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч /Л.Цэдэвсүрэн/-д даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

D/2022/Tushaal/

142210597

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2022 оны 05 дугаар сарын 05 -ны өдрийн
АМСГ тушаалын 1 дүгээр хавсралт



**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ
ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Нэг. Үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай факт, Хүүхдийн эрхийн тухай конвенц Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг тус тус үндэслэн сургуулийн өмнөх боловсролын салбар дахь хүүхдийн эрхийн асуудлаар тавигдаж буй асуудал, түүний нөхцөл байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

Хоёр. Зорилго:

НҮБ-ын Сурч боловсрох эрхийн тусгай илтгэгч Катарина Томашевскийн тодорхойлсон хүний эрхийн 4А (making education available, accessible, acceptable, and adaptable) болох “Хүрэлцээтэй байх, Хүртээмжтэй байх, Хүлээн зөвшөөрөгдсөн байх, Нийцэн зохицох” гэсэн дөрвөн хэмжүүрээр Монгол Улсын Үндсэн хууль, боловсролын салбарын хууль тогтоомж болон олон улсын гэрээгээр хүлээсэн хүний эрхийг хангах үүрэг, хариуцлагын хэрэгжилтийг түүврээр сонгогдсон төрөл бүрийн хэв шинж бүхий сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан үр дүнд үндэслэн дүгнэлт санал боловсруулах, холбогдох байгууллагуудад санал, шаардлага, зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулахад оршино.

2.1. Зорилт:

- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй дүрэм журам, баримт бичиг нь хүүхдийн эрхэд суурилсан, бодитой, хүртээмжтэй, нийцтэй, чанартай байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт хийх;
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд хууль эрх зүй, хүний эрхийн чиглэлээр агуулга тусгагдсан эсэхэд үнэлэлт, дүгнэлт хийх;
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтад ашиглагдаж буй гарын авлага, сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийн агуулгад

хүүхдийн эрхийг хангасан, жендерийн эрх тэгш байдалд нийцсэн, хүчирхийллийг дэмждэггүй, хүний эрхийг хүндэтгэсэн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаанд мөрдөж буй дүрэм журам, баримт бичиг, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагад санал, зөвлөмж боловсруулан хүргүүлэх;
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтад ашиглагдаж буй гарын авлага, сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийн агуулгад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээнд үндэслэн гарын авлага, сургалтын агуулгыг сайжруулах санал, зөвлөмжийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаа:

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагчдын сурч боловсрох, сурган хүмүүжүүлэх үүрэг хүлээгчдийг 4А хэмжүүрийн хүрээнд одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөө нь хүний эрхэд суурилсан эсэхэд дүн шинжилгээ хийж, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сургалтын байгууллагын орчинд хэрхэн авч хэрэгжүүлдэг талаар хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийнэ.

Тус үйл ажиллагааг зохион байгуулахдаа ажиглалт, тандалт, тоон болон чанарын аргуудыг хослуулан, сонгогдсон сургалтын байгууллагын удирдлага, багш ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдаас тайлбар тодруулга, асуулга судалгаа авах, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх холбогдох баримт материалыг гаргуулах, хуулбарлан авах, шаардлагатай тохиолдолд дуу, дүрсний техник хэрэгсэл ашиглаж баримтжуулах хэлбэрээр ажиллана.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

1. Хүрэлцээтэй байх

- Тухайн баг, хорооны нутаг дэвсгэр болон хамран сургах тойрогт хангалттай тооны цэцэрлэгтэй эсэх;
- Цэцэрлэгийн орчин нь эрүүл, аюулгүй, хүчирхийллээс ангид байх, хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй, тэдэнд эрх тэгш ханддаг орчин нөхцөл бүрдүүлсэн эсэх;
- Цэцэрлэгийн сургалтын орчин нь (гадаад орчин /гэрэлтүүлэг, хашаа, хайс, зам талбай, цахилгааны шит утас, дээврийн аюулгүй байдал, хамгаалалт, авто замын тэмдэг, тэмдэглэгээ/, дотоод орчин /сургалтын хэрэглэгдэхүүн, тавилга эд хогшил, хаалга, цонх, шал, шатны бариул, хоол үйлдвэрлэлийн ариутгал, халдваргүйтгэл, цахилгааны монтаж,

сантехник, ариун цэврийн байгууламж/-ы аюулгүй байдал) орчны стандарт, ерөнхий шаардлагад нийцсэн эсэх;

- Багшлахуй ба суралцахуйд шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, ном, гарын авлага, материал болон бусад тоног төхөөрөмжөөр хангагдсан эсэх;
- Хүүхдийн эрхийн үүрэг, хариуцлагыг биелүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгө, нөөцийг хуваарилсан, хяналт тавьсан эсэх;

2. Хүртээмжтэй байх

- Хүүхдийг цэцэрлэгт элсүүлэхээс татгалзах, ялгаварлах байдлыг тодорхойлон эцэг эхийн сонголтыг хүндэтгэсэн эсэх;
- Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгт чанартай боловсрол олгох чиглэлээр хийсэн ажлын үр дүнг тооцсон эсэх;
- Цэцэрлэгийн ачаалал, бүлэг дүүргэлтээс хамааран хүүхдийн сурч, хөгжих эрхэд нөлөөлөл үүсдэг эсэх;
- Сургуульд элсэхийн өмнөх насны (5 нас) хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулж, сургуулийн өмнөх боловсрол олгох ажлыг зохион байгуулсан эсэх;
- Хүүхэд хамгааллын бодлого, хүүхэд хамгааллын баг, хүүхэд хамгааллын чиглэлээр хийсэн ажлын төлөвлөгөөний биелэлт хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцсон эсэх;
- Гадаад ба дотоод орчны эрсдэлийн үнэлгээ хийж зөрчлийг арилгах арга хэмжээ авсан эсэх; (MNS 6558:2015)

3. Хүлээн зөвшөөрөгдсөн байх

- Цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь хүүхдийн эрхэд суурилсан, бодитой, хүртээмжтэй үр дүн нь хэмжигдэхүйц байхаар төлөвлөсөн эсэх;
- Нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй дотоод дүрэм, журам, баримт бичигт хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлийн асуудлыг оновчтой тусгаж, хэрэгжилтийг хангасан эсэх;
- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөлтөд хүүхдийн эрхийг хүндэтгэсэн, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлийн агуулгыг тусган хэрэгжүүлдэг эсэх;
- Бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэл болон үл хайхрах байдал, мөлжлөгөөс хүүхдийг хамгаалах үзэл санаа, үйл ажиллагааг өөрийн байгууллагын түвшинд нэвтрүүлэх, дадал болгох, дотоод журамдаа тусгасан эсэх;
- Эцэг эх, асран хамгаалагчтай байгуулах гурвалсан гэрээнд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын чиглэлээр тусгасан эсэх;

- Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ хийж, үр дүн, хэрэгжилтийг хангаж ажилладаг эсэх;
- Хүүхэд хамгааллын чиглэлээр анхаарах эрсдэлийн хүчин зүйлсийн үнэлгээнд үндэслэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн эсэх;

4. Нийцэн зохицох

- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангахад гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажилласан эсэх;
- Хөгжлийн бэршээлтэй хүүхдийг цэцэрлэгт хамруулах, сурах, хөгжих тэгш боломж олгосон эсэх; (тухайлбал хэт хөдөлгөөнт, анхаарлын дутмагшилтай, аутизмтай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд)
- Цэцэрлэг хүүхдийн эрх нь зөрчигдсөн, ялгаварлан гадуурхагдсан, хаягдсан, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулдаг эсэх;

Дөрөв. Ажлын хамрах хүрээ:

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагыг түүврийн аргаар сонгох бөгөөд нэрсийн жагсаалтыг удирдамжид тусгасан байна.

Тав. Хугацаа:

Эхлэх хугацаа: 2022.08.01.

Дуусах хугацаа: 2022.10.01

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүлээгдэж буй үр дүн:

- 6.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасны дагуу холбогдох байгууллагад Хүний эрхийн Үндэсний Комиссын санал, шаардлага, зөвлөмжийг хүргүүлнэ.
- 6.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн өмнөх боловсролын байгууллагад мөрдөж буй дүрэм журам, баримт бичиг, үйл ажиллагаа нь хүүхдийн эрхэд суурилсан, ялгаварлан гадуурхалтгүйгээр бүх хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахад чиглэнэ.
- 6.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулгыг хүүхдийн эрхийг хангасан, жендерийн эрх тэгш байдалд нийцсэн, хүчирхийллийг дэмждэггүй, хүний эрхийг хүндэтгэсэн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байхад дэмжлэг үзүүлнэ.

- 6.4. Боловсролын салбарт хүүхэд, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдын зөрчигдөж буй эрхийг илрүүлж, таслан зогсоох, цаашид эрх нь зөрчигдөхөөс урьдчилсан сэргийлэх арга хэмээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 6.5. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үзүүлэхэд цэцэрлэгийн бүлгийн ачаалал нь хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байна.
- 6.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд хүүхдийн эрхийг хангасан, жендерийн эрх тэгш байдалд нийцсэн, хүчирхийллийг дэмждэггүй, хүний эрхийг хүндэтгэсэн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сурч боловсрох эрхийн хэрэгжилт дээшилсэн байна.
- 6.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд суурилан 4А гэсэн гол хэмжүүрээр боловсролын бүх шатлал, түвшинд байх ёстой чухал шинжүүдийг тодорхойлон хэрэгжүүлэхэд нөлөөлнө.
- 6.8. Дүрэм журам, баримт бичиг, үйл ажиллагаанд 4А гол хэмжүүрүүдийг тусган хүүхдийн эрхэд суурилсан, ялгаварлан гадуурхалтгүйгээр сурч боловсрох эрхийг хангахад чиглүүлнэ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2022 оны 05 дугаар сарын 05 -ны өдрийн
NISG тушаалын 2 дугаар хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

Нэг. Үндэслэл

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай факт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, болон бусад холбогдох хууль, тогтоомжийг тус тус үндэслэн ерөнхий боловсролын салбар дахь хүүхдийн эрхийн асуудлаар тавигдаж буй асуудал, түүний нөхцөл байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

Хоёр. Зорилго

НҮБ-ын Сурч боловсрох эрхийн тусгай илтгэгч Катарина Томашевскийн тодорхойлсон хүний эрхийн 4А (making education available, accessible, acceptable, and adaptable) болох “Хүрэлцээтэй байх, Хүртээмжтэй байх, Хүлээн зөвшөөрөгдсөн байх, Нийцэн зохицох” гэсэн дөрвөн хэмжүүрээр Монгол Улсын Үндсэн хууль, боловсролын салбарын хууль тогтоомж болон олон улсын гэрээгээр хүлээсэн хүний эрхийг хангах үүрэг, хариуцлагын хэрэгжилтийг түүврээр сонгогдсон төрөл бүрийн хэв шинж бүхий ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан үр дүнд үндэслэн дүгнэлт санал боловсруулах, холбогдох байгууллагуудад санал, шаардлага, зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулахад оршино.

2.1. Зорилт

- Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй дүрэм журам, баримт бичиг нь хүний эрхэд суурилсан, бодитой, хүртээмжтэй, нийцтэй, чанартай байгаа эсэх, боловсролын харилцаанд оролцогчдын эрх үүргийг оновчтой тодорхойлсон эсэхэд үнэлэлт, дүгнэлт хийх;
- Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд хууль эрх зүй, хүний эрхийн чиглэлээр агуулга тусгагдсан эсэхэд үнэлэлт, дүгнэлт хийх;
- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчны стандарт, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийн агуулга нь хүүхдийн эрхийг хангасан, жендерийн эрх тэгш байдалд нийцсэн, хүчирхийллийг дэмждэггүй, хүний

эрхийг хүндэтгэсэн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

- Багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчид боловсролын харилцаанд аливаа ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид, хүн бүр эрх, тэгш оролцох боломжийг бүрдүүлж буй байдалд үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулах;
- Ерөнхий боловсролын салбарт хүний эрхийг хангаж байгаа нөхцөл байдалд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээнд үндэслэн бодлого, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах санал, зөвлөмжийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх.

Гурав. Хяналт- шинжилгээ үнэлгээ хийх үйл ажиллагаа

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын сурч боловсрох, сурган хүмүүжүүлэх үүрэг хүлээгчдийг 4А хэмжүүрийн хүрээнд одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөө нь хүний эрхэд суурилсан эсэхэд дүн шинжилгээ хийж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сургалтын байгууллагын орчинд хэрхэн авч хэрэгжүүлдэг талаар хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийнэ. Тус үйл ажиллагааг зохион байгуулахдаа ажиглалт, тандалт, тоон болон чанарын аргуудыг хослуулан, сонгогдсон сургалтын байгууллагын удирдлага, багш ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдаас тайлбар тодруулга, асуулга судалгаа авах, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага хийх холбогдох баримт материалыг гаргуулах, хуулбарлан авах, шаардлагатай тохиолдолд дуу, дүрсний техник хэрэгсэл ашиглаж баримтжуулах хэлбэрээр ажиллана.

Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ:

5. Хүрэлцээтэй байх

- Тухайн сургууль нь нутаг дэвсгэрийн хамран сургах тойргийн хүүхдүүдийг бүрэн хамарч, бага, суурь, бүрэн дунд боловсрол олгож буй эсэх;
- Сургуулийн сургалтын орчин, сурагчдын дотуур байр нь Монгол Улсын стандарт “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS6782:2019”, “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ Ерөнхий шаардлага MNS6781:2019” -д тус тус нийцсэн эсэх;
- Тухайн сургуулийн 1-12 дугаар ангийн бүлэг дүүргэлт, багшийн хүрэлцээ хангамж, нэг багшид ногдох сурагчдын тоо нь эрх бүхий байгууллагаас тогтоосон норм, дүрэм журамд нийцэж буй эсэх;
- Нэг суултуур, угаалтуурт ногдох хүүхдийн тоо, ариун цэврийн өрөө багш, суралцагчдад хүрэлцээтэй эсэх;
- Мэдээллийн технологи, харилцаа холбооны хэрэгсэл, тоног төхөөрөмж, интернэтийн сүлжээ нь суралцагч, багш, ажилтанд хүрэлцээтэй эсэх;

- Сургалтын орчин, дотуур байранд багш, ажилтан, хүүхдэд эрүүл, аюулгүй, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид, эрх тэгш ажиллах, суралцах орчин нөхцөл бүрдүүлсэн эсэх;
- Багшлахуй ба суралцахуйд шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, ном, гарын авлага, материал болон бусад тоног төхөөрөмжөөр хангагдсан эсэх;
- Хүүхдийн эрхийн үүрэг, хариуцлагыг биелүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгө, нөөцийг хуваарилсан, хяналт тавьсан эсэх;

6. Хүртээмжтэй байх

- 1-12 дугаар ангийн бүлэг дүүргэлт, ээлжийн коэффициент, мэргэжлийн багшийн хүрэлцээ хангамж зэрэг үзүүлэлтүүд суралцагчийн сурах, хөгжих эрхэд нөлөөлж буй эсэх;
- Хамран сургах тойргийн 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулсан эсэх;
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хүүхдүүд эрх тэгш хамрагдаж буй эсэх;
- Хүүхдийг сургуульд элсүүлэхээс татгалзах, ялгаварлах байдлыг тодорхойлох;
- Гадаад ба дотоод орчны эрсдэлийн үнэлгээ хийж зөрчлийг арилгах арга хэмжээ авсан эсэх;
- Хүүхэд хамгааллын бодлого, хүүхэд хамгааллын баг, хүүхэд хамгааллын чиглэлээр хийсэн ажлын төлөвлөгөөний биелэлт хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцсон эсэх;
- Хамран сургах тойргийн сургуулиас гадна байгаа хүүхдийг тодорхойлох, бага, суурь, бүрэн дунд боловсролын үйлчилгээнд эргүүлэн авчрах, сургах, сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн.

7. Хүлээн зөвшөөрөгдсөн байх

- Сургуулийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө нь хүний эрхэд суурилсан, бодитой, хүртээмжтэй үр дүн нь хэмжигдэхүйц байхаар төлөвлөсөн эсэх;
- Байгууллагын дотоод дүрэм журам, баримт бичигт суралцагч, багш, ажилтныг эрхийг хамгаалах зохицуулалтыг оновчтой тусгаж, хэрэгжилт хангагдсан эсэх;
- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичигт хүүхдийн эрхийг хүндэтгэсэн, хүний эрхийг хамгаалах талаар агуулгыг тусган хэрэгжүүлдэг эсэх;
- Суралцагч, багш, ажилтны нууц, нэр төрийг хамгаалах, хадгалах нөхцөл боломжийг бүрдүүлсэн эсэх;

- Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ хийж, үр дүн, хэрэгжилтийг хангаж ажилладаг эсэх;
- Эцэг эх, асран хамгаалагчтай байгуулах гурвалсан гэрээнд хүүхдийн эрхийг хамгаалах, эцэг эх, багшийн оролцоо, эрх тэгш байдлыг хангах чиглэлээр тусгасан эсэх;
- Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт, ажилд авах, хөдөлмөрлөх эрх, үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хангасан эсэх;

8. Нийцэн зохицох

- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангахад гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажилласан эсэх;
- Эрх нь зөрчигдсөн, ялгаварлан гадуурхагдсан, үл хайхрах болон бие мах бод сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулдаг эсэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, сурах, хөгжих тэгш боломж олгосон эсэх; (тухайлбал хэт хөдөлгөөнт, анхаарлын дутмагшилтай, аутизмтай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд)
- Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр дамжуулан жендерийн эрх тэгш байдалд нийцсэн, хүчирхийллийг дэмждэггүй байх төлөвшлийг олгож хэвшүүлдэг эсэх;
- багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчид боловсролын харилцаанд оролцохдоо аливаа ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид, хүн бүрт эрх, тэгш хандах боломжийг бүрдүүлэх;
- Орон нутгийн эрэлт хэрэгцээ ба хам нөхцөлд хариу үйлдэл үзүүлдэг эсэх.

Дөрөв. Ажлын хамрах хүрээ:

Ерөнхий боловсролын сургалтын байгууллагыг түүврийн аргаар сонгох бөгөөд нэрсийн жагсаалтыг удирдамжид тусгасан байна.

Тав. Хугацаа:

Эхлэх хугацаа: 2022.08.01.

Дуусах хугацаа: 2022.10.01

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүлээгдэж буй үр дүн

6.9. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасны

дагуу холбогдох байгууллагад Хүний эрхийн Үндэсний Комиссын санал, шаардлага, зөвлөмжийг хүргүүлнэ.

- 6.10. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд суурилан ерөнхий боловсролын сургалтын байгууллагад мөрдөж буй дүрэм журам, баримт бичиг, үйл ажиллагаа нь хүний эрхэд суурилсан, хэнийг ч ялгаварлан гадуурхахгүйгээр бүх хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахад чиглэнэ.
- 6.11. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд ерөнхий боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулгыг хүүхдийн эрхийг хангасан, жендерийн эрх тэгш байдалд нийцсэн, хүчирхийллийг дэмждэггүй, хүний эрхийг хүндэтгэсэн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байхад дэмжлэг үзүүлнэ.
- 6.12. Боловсролын салбарт хүүхэд, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдын зөрчигдөж буй эрхийг илрүүлж, таслан зогсоох, цаашид эрх нь зөрчигдөхөөс урьдчилсан сэргийлэх арга хэмээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 6.13. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд хүүхдийн эрхийг хангасан, жендерийн эрх тэгш байдалд нийцсэн, хүчирхийллийг дэмждэггүй, хүний эрхийг хүндэтгэсэн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сурч боловсрох эрхийн хэрэгжилт дээшилсэн байна.
- 6.14. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд суурилан 4А гэсэн гол хэмжүүрээр боловсролын бүх шатлал, түвшинд байх ёстой чухал шинжүүдийг тодорхойлон хэрэгжүүлэхэд нөлөөлнө.
- 6.15. Дүрэм журам, баримт бичиг, үйл ажиллагаанд 4А гол хэмжүүрүүдийг тусган хүүхдийн эрхэд суурилсан, ялгаварлан гадуурхалтгүйгээр сурч боловсрох эрхийг хангахад чиглүүлнэ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2022 оны 05 дугаар сарын 05 -ны өдрийн
A156 тушаалын 3 дугаар хавсралт

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ
ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

/төсөл/

Нэг. Үндэслэл

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай факт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсролын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг тус тус үндэслэн мэргэжлийн болон техникийн боловсролын салбар дахь хүний эрхийн асуудлаар тавигдаж буй асуудал, түүний нөхцөл байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

Хоёр. Зорилго

НҮБ-ын Сурч боловсрох эрхийн тусгай илтгэгч Катарина Томашевскийн тодорхойлсон хүний эрхийн 4А (making education available, accessible, acceptable, and adaptable) болох “Хүрэлцээтэй байх, Хүртээмжтэй байх, Хүлээн зөвшөөрөгдсөн байх, Нийцэн зохицох” гэсэн дөрвөн хэмжүүрээр Монгол Улсын Үндсэн хууль, боловсролын салбарын хууль тогтоомж болон олон улсын гэрээгээр хүлээсэн хүний эрхийг хангах үүрэг, хариуцлагын хэрэгжилтийг түүврээр сонгогдсон төрөл бүрийн хэв шинж бүхий мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан үр дүнд үндэслэн дүгнэлт санал боловсруулах, холбогдох байгууллагуудад санал, шаардлага, зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулахад оршино.

2.1. Зорилт

- Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн үйл ажиллагаанд мөрдөж буй дүрэм журам, баримт бичиг нь хүүхдийн эрхэд суурилсан, бодитой, хүртээмжтэй, нийцтэй, чанартай байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт хийх.
- Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн сургалтын хөтөлбөрийн агуулгад хууль эрх зүй, хүний эрхийн чиглэлээр агуулга тусгагдсан эсэхэд үнэлэлт, дүгнэлт хийх.

- Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн сургалтын үйл ажиллагаанд ашиглаж буй гарын авлага, сурах бичгийн агуулгад хүүхдийн эрхийг хангасан, жендерийн эрх тэгш байдалд нийцсэн, хүчирхийллийг дэмждэггүй, хүний эрхийг хүндэтгэсэн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.
- Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн сургалтын үйл ажиллагаанд мөрдөж буй дүрэм журам, баримт бичиг, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагад санал, зөвлөмж боловсруулах.
- Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн сургалтад ашиглагдаж буй гарын авлага, сурах бичгийн агуулгад хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээнд үндэслэн гарын авлага, сурах бичгийн агуулгыг сайжруулах санал, зөвлөмжийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх.

Гурав. Хяналт- шинжилгээ үнэлгээ хийх үйл ажиллагаа

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын сурч боловсрох, сурган хүмүүжүүлэх үүрэг хүлээгчдийг 4А хэмжүүрийн хүрээнд одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөө нь хүний эрхэд суурилсан эсэхэд дүн шинжилгээ хийж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сургалтын байгууллагын орчинд хэрхэн авч хэрэгжүүлдэг талаар хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийнэ. Тус үйл ажиллагааг зохион байгуулахдаа ажиглалт, тандалт, тоон болон чанарын аргуудыг хослуулан, сонгогдсон сургалтын байгууллагын удирдлага, багш ажилтан, суралцагчдаас тайлбар тодруулга, асуулга судалгаа авах, ганцаарчилсан болон фокус группийн ярилцлага хийх холбогдох баримт материалыг гаргуулах, хуулбарлан авах, шаардлагатай тохиолдолд дуу, дүрсний техник хэрэгсэл ашиглаж баримтжуулах хэлбэрээр ажиллана.

4А хэмжүүрийн хүрээнд дараах асуудлуудад хяналт-шинжилгээ үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэнэ: Үүнд:

Хүрэлцээтэй байх:

- МСҮТ, политехник коллежийн сургалтын орчин аюулгүй байх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан эсэх (дадлагын газар, үйлдвэрлэл сургалтын дадлагын үеэр хэрэглэгдэх техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, анги танхим, номын сан, ариун цэврийн байгууламж);
- Чанартай багшлахуйн талаар (мэргэжлийн болон ерөнхий эрдмийн хичээл заадаг багшийн боловсрол, мэргэжил дээшлүүлэх сургалт, ажилд авах, хөдөлмөрлөх эрх, үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх чөлөө;)

- Суралцагчийн үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулдаг ажил олгогч аж ахуйн нэгжийн ажиллах орчин нөхцөл нь хүний эрхийг дээдэлсэн орчин бүрдүүлсэн эсэх;
- Хүний эрхийн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд шаардагдах хөрөнгө, нөөцийг оновчтой хуваарилсан эсэх;
- Багшлахуй ба суралцахуйд шаардлагатай сургалтын материал ба бусад тоног төхөөрөмжөөр хангагдсан эсэх;

Хүртээмжтэй байх:

- Боловсролын бүх хэлбэр, шатлал, түвшинд үл ялгаварлан гадуурхалт байгаа эсэх;
- Эрх зүйн болон захиргааны бүх саад тотгорыг арилгасан эсэх;
- Элсүүлэхээс татгалзах, ялгаварлах байдлыг тодорхойлох;
- Сургалтын төлбөр болон бусад санхүүгийн саад тотгорыг арилгасан эсэх;
- Үнэ төлбөргүй мэргэжил эзэмших, ажил олгогчийн захиалгын дагуу сургалтанд хамрагдсан, мэргэжлийн боловсролыг бүрэн дунд боловсролтой хослуулан эзэмшсэн эсэх;
- Эрт гэрлэлт, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт зэрэг өсвөр үеийнхнийг сургуулиас гадна байлгадаг практикуудыг судалж тогтоон холбогдох арга хэмжээ авсан эсэх;
- Сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх болон сургуулийн гадна байгаа хүүхдийг тодорхойлох, улмаар мэргэжлийн боловсрол сургалтын тогтолцоонд эргүүлэн авчрах, насан туршийн суралцахуй, насан туршийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг авсан эсэх;
- Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм журам, бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөөнд хүний эрхийн агуулга тусгагдсан эсэхэд дүн шинжилгээ хийх;

Хүлээн зөвшөөрөгдсөн байх:

- Төрийн болон төрийн бус өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад чанартай боловсрол, ажил мэргэжлийн стандартад тусгагдсан ур чадварыг олгосон эсэх (сургалтын хөтөлбөр, сурган арга зүй, бэлтгэгдсэн багш) ;
- Мэргэжлийн боловсрол сургалтын зорилгыг хэрэгжүүлсэн эсэх;
- Соёлын хувьд нийлэмжтэй, тухайн суралцагчид олгож буй хөтөлбөр нь мэргэшлийн үндэсний хүрээтэй нийцтэй эсэх;
- Хүчирхийллийн аливаа хэлбэрээс ангид, охид эмэгтэйчүүдийн эсрэг жендерт суурилсан хүчирхийлэлгүй ба бие махбодын шийтгэл үзүүлдэг эсэх;
- Өөрсдийн сүсэг бишрэл, ёс суртахууны ба философийн итгэл үнэмшилд нийцүүлэн эцэг эхчүүд хүүхдээ хувийн сургуульд явуулах эрх чөлөөтэй байгаа эсэх (төрийн өмчийн сургуульд нейтраль ба үл ялгаварлах байдлаар шашны ба ёс зүйн хичээлийг заах замаар тэдний итгэл үнэмшлийг хүндэтгэн үзэх);

Нийцэн зохицох:

- Суралцагчийн өвөрмөц хэрэгцээ хангагдсан эсэх (тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнхийн, ЛГБТИК хүүхдүүд, хөдөлмөр эрхэлдэг, хөдөөгийн малчдын хүүхэд, хорих газарт байгаа хүүхдүүд зэрэг);
- Нийгмийн хувьсан өөрчлөгдөж байгаа эрэлт, хэрэгцээнд нийцсэн эсэх;
- Орон нутгийн эрэлт хэрэгцээ ба хам нөхцөлд хариу үйлдэл үзүүлж байгаа эсэх;

Дөрөв Ажлын хамрах хүрээ

- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын түүврийн аргаар сонгох бөгөөд нэрсийн жагсаалтыг удирдамжид тусгасан байна.

Тав. Хугацаа

Эхлэх хугацаа: 2022.08.01.

Дуусах хугацаа: 2022.10.01

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүлээгдэж буй үр дүн

- 6.16. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасны дагуу холбогдох байгууллагад Хүний эрхийн Үндэсний Комиссын санал, шаардлага, зөвлөмжийг хүргүүлнэ.
- 6.17. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд суурилан мэргэжлийн болон техникийн боловсролын сургуульд хүүхэд элсэх болон шилжин суралцахад мөрдөж буй дүрэм журам, баримт бичиг, үйл ажиллагаа нь хүүхдийн эрхэд суурилсан, ялгаварлан гадуурхалтгүйгээр бүх хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахад чиглэнэ.
- 6.18. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд мэргэжлийн болон техникийн боловсролын сургуульд сургалтын гарын авлага, сурах бичгийн агуулгыг хүүхдийн эрхийг хангасан, жендерийн эрх тэгш байдалд нийцсэн, хүчирхийллийг дэмждэггүй, хүний эрхийг хүндэтгэсэн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байхад дэмжлэг үзүүлнэ.
- 6.19. Боловсролын салбарт хүүхэд, багш, ажилтан, эцэг эхчүүдийн зөрчигдөж буй эрхийг илрүүлж, таслан зогсоох, цаашид эрх нь зөрчигдөхөөс урьдчилсан сэргийлэх арга хэмээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 6.20. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд хүүхдийн эрхийг хангасан, жендерийн эрх тэгш байдалд нийцсэн, хүчирхийллийг дэмждэггүй, хүний эрхийг хүндэтгэсэн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сурч боловсрох эрхийн хэрэгжилт дээшилсэн байна.

- 6.21. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд суурилан 4А гэсэн гол хэмжүүрээр боловсролын бүх шатлал, түвшинд байх ёстой чухал шинжүүдийг тодорхойлон хэрэгжүүлэхэд нөлөөлнө.
- 6.22. Дүрэм журам, баримт бичиг, үйл ажиллагаанд 4А гол хэмжүүрүүдийг тусган хүүхдийн эрхэд суурилсан, ялгаварлан гадуурхалтгүйгээр сурч боловсрох эрхийг хангахад чиглүүлнэ.

**МСҮТ, ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН БАГШ, СУРАЛЦАГЧТАЙ ХИЙХ БҮЛГИЙН
ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУУДАС**

Мэдээлэл цуглуулсан:

- Огноо
- Ажлын хэсгийн гишүүн

Оролцсон багшийн мэдээлэл:

Багш нарын тоо:	Сургууль	Сургуулийн өмчийн хэлбэр	Нас	Хүйс	Боловсролын зэрэг	Мэргэжил	Багшаар ажилласан жил	Төгссөн сургууль
Б1								
Б2								

ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТ

№	Чиглүүлэх асуулт	Тэмдэглэл
	1. Сургуулийн хөтөлбөрт эрх зүйн агуулгыг тусгасан байдал	
1.	Танай сургуулийн суралцагчдын дунд ямар чиглэлийн зөрчил, үйл ойлголцол гардаг вэ? Тухайлбал, бие биеэ дээрэлхэх, ялгаварлах, цахим халдлагад өртөх г.м	
2.	Суралцагч эрх зүйн аль агуулга, сэдвийг илүү сонирхдог вэ? Мөн ямар сэдвийг тэд сонирхдоггүй вэ? яагаад? Дээрх хэлсэн зөрчил, асуудлыг шийдэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд эрх зүйн мэдлэг, чадвар хэрхэн нөлөөлөх бол?	
3.	Эрх зүйн агуулгаар суралцагчдын ямар мэдлэг, чадвар хөгжүүлэхэд илүү анхаардаг вэ? яагаад? суралцагчдаа ямар мэдлэг, чадварыг эзэмшээсэй гэж хүсдэг вэ?	
4.	Суралцагчдад хууль, эрх зүйн хүний эрхтэй холбоотой ямар үнэт зүйл, зарчим төлөвшүүлэх шаардлагатай гэж та үзэж байна вэ? Энэ нь тэдэнд хэр зэрэг төлөвшсөн байгаа бол, Таны бодож байгаагаар?	
5.	Танд сургалтаа зохион байгуулахад шаардлагатай анги кабинет, ном сурах бичиг, орчин хэр бүрдсэн байдаг вэ?	
6.	-Харилцааны ёс зүй, эрх зүй хичээлийн агуулгад эрх зүйн ямар чиглэл илүү тусгасан байдаг вэ? -Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүйн агуулгуудыг интеграци байдлаар заах боломжтой юу? заахад цаг хүрэлцээтэй юу	
	2. Хүний эрхийн талаар эрх зүйн агуулгыг зохион байгуулж буй байдал	
7.	-Танай сургуулийн хичээлийн хөтөлбөрт хүний эрхтэй холбоотой агуулгыг хэдэн цагаар судлахаар төлөвлөдөг вэ? Судалж буй цаг	

	тохиромжтой эсэх/ -Энэ агуулгыг судлах лекц, семинарын цагийн харьцаа хангалттай юу	
8.	Хүний эрхийн талаарх соёл олон нийтийн ажлыг танай сургууль хэрхэн яаж зохион байгуулдаг вэ?	
9.	Танай сургуулийн суралцагч элсүүлэх журам тэдний адил тэгш ялгаврлан гадуурхалтад өртөхгүй байхад нөлөөдөг үү. Жн:Хүссэн мэргэжлийн ангидаа орж суралцах...	
10.	Таны бодлоор хүүхүүдийн хууль эрх зүйн мэдлэг чадварыг дэмжихэд сургалтын ямар арга илүү үр дүнтэй вэ? Сурагч төвтэй сургалтыг зохион байгуулахад ямар хүндрэл бэрхшээл тулгамдаж байна вэ? (хосоор болон багаар ажиллуулах, сурагчдын ялгаатай байдлыг харгалзах ялгаатай үйл ажиллагааг хийлгэх, суралцах бэрхшээлтэй сурагчидтай ажиллах гэх мэт.)	
11.	Та хүний эрхийн талаар сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулахдаа мэдээллийн ямар эх сурвалжуудыг ашиглаж байна вэ? (Видео бичлэг, хууль зүйн жишээ, тохиолдлын сан, цахим е-хөтөч, цахим хууль эрх зүйн сан г.м.)	
12.	Үйлдвэр дээрх дадлагын хугацаанд суралцагчдын эрх зөрчигддөг үү таны бодол.Дадлага хийх гэрээний дагуу ажиллах, ажлын байрны ямар нэгэн дарамт шахалтад өртөх гэх мэт.	
13.	Багш, суралцагч өөрсдийнх нь эрх хөндөгдвөл хаана, хэнд хэрхэн хандах талаар мэддэг болов уу? Хууль, эрх зүйн болон бусад ямар асуудлаар сурагчид танд ханддаг уу? Та зөвлөгөө өгч байсан бодит жишээ баримт кейс хэлнэ үү.	
14.	Багш, ажилтны хүний эрхийн талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэхэд ямар арга хэлбэр (танхимын, танхимын бус, тогтолцооны хувьд албан, албан бус, арга зүйн хувьд оролцооны, уламжлалт гэх мэт) хамгийн тохиромжтой гэж та үзэж байна вэ? Яагаад?	
15.	Суралцагч, багш нарынхаа эрхийг хамгаалах, хамтран ажиллах талаар танай сургуулийн удирдлага, Нийгмийн ажилтнууд хир ажилладаг гэж үзэж байна.	
16.	Суралцагчдын эрхийг хамгаалахад танд ямар бэрхшээлүүд тулгардаг вэ? (заах арга зүй, хичээлийн агуулгын талаар, багшийн эрх зүйн мэдлэг, чадвар, ном сурах бичгийн хүртээмж номын сан, нийгмийн ажилтны хүрэлцээ гэх мэт). Тайлбарлана уу	
17.	Өнөөгийн байдлаар суралцагсдын эрх зүйн мэдлэг ямар түвшинд байгаа гэж Та үзэж байна? Яагаад? (1-5 балаар үнэлвэл)	
	3. Суралцагчдын үнэлгээ, эргэх холбоог тогтоох байдал, сайжруулах санал	
	1. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг уу?Тэднийг эрх	

18	<p>тэгш үнэлж чаддаг уу?</p> <p>2. Явцын болон чадамжийн үнэлгээг та ямар зорилгоор сургалт, үйл ажиллагаандаа хэрэглэж байна вэ?</p> <p>3. Суралцагчийг үнэлэхэд танд ямар хүндрэл бэрхшээл гарч байна вэ?</p> <p>4. Суралцагчдын сурлагын амжилтыг бодитой үнэлэх ямар сайн туршлага, арга замууд танд байна вэ? Тэдгээрийн давуу талыг дурдана уу.</p>	
19	<p>1. Танай сургууль эрх зүй хөтөлбөрийн хөгжүүлэлт хэдэн удаа хийсэн бэ? Эрх зүй хөтөлбөрийн хөгжүүлэлтээ ямар чиглэлээр хийсэн бэ?</p> <p>2. Хичээлд суралцах үүрэг, хариуцлагаа суралцагчид хэр биелүүлсэн бэ?</p>	
	Цаашид үр дүнтэй, хүртээмжтэй хэрэгжүүлэхэд юуг анхаарах шаардлагатай байгаа вэ?	
20	<p>1. Хэрэв эрх зүйн агуулга хөтөлбөрт тусгаагүй бол эрх зүйн агуулгыг нэмж оруулах шаардлагатай юу? Тайлбарлана уу.</p> <p>2. Эрх зүйн агуулгыг тусад нь хичээл болгон орох шаардлагатай юу? Таны санал</p>	
	Эрх зүйн хичээлийн агуулгад зайлшгүй тусгах шаардлагатай агуулга сэдвээс нэгийг нэрлэнэ үү. Яагаад?	